

## ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	6
ГУРАВДУГААР БҮЛЭГ. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ .....	7
3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажил	7
3.2. Уурхайн нөхөн сэргээлт .....	8
3.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ.....	11
Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд бөгөөд тухайн онд ямар нэг ажлыг төлөвлөөгүй болно. ....	11
3.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ .....	11
3.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ .....	11
3.6 Химийн бодисын эрсдлийн менежмент .....	11
3.7 Хог, хаягдлын менежмент.....	11
3.8 Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежмент .....	11
3.9 Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр.....	12
Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу агаар , ус, хөрсний шинжилгээнүүдийг өгсөн болно. ....	12
3.10.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	12

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### Төслийн товч танилцуулга

№	Үзүүлэлтүүд	Утга
1	Аж ахуйн нэгжийн нэр	“Монгол базальт”ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар	
3	Уурхайн нэр	“Ногоон уул”
4	Ордын нэр	“Ногоон уул”
5	Ордын байршил	Аймаг/Хот
6		Сум/Дүүрэг
7	Ашигт малтмалын төрөл	Базальт
8	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-017426
9	Ашиглалт эхэлсэн огноо	
10	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот
11		Сум/Дүүрэг
12		Баг/Хороо
13		Гудамж/Байр
14		Шуудангийн
15		Утас
16		Факс
17		Гар утас
18		Электрон
19		Вэб хуудас
20		Нэр
21		Утас
22	Факс	
23	Гар утас	
24	Электрон	
25	Нөөцийн тайлан хэлэлцсэн ЭБМЗ-ийн хурлын огноо, дүгнэлтийн дугаар	2011-09-06, №XX-16-04
26	Нөөцийг бүртгэсэн шийдвэрийн огноо, дугаар	2011-09-14, №39
27	Анхны нөөцийн хэмжээ	B-2031301,7тн : C-
28	Тухайн оны эхэн дэх нөөцийн хэмжээ	
29	ТЭЗҮ-ийн дүгнэлтийн огноо, дугаар	2016-04-20, №16-04-20
30	Ашиглах хугацаа	
31	Жилийн хүчин чадал	
32	Урьд онуудад гаргасан бүтээгдэхүүний	843,65 тн
33	Тухайн онд гаргасан бүтээгдэхүүний	1387,7 тн

## 1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### 1.1. Ордын байршил


Төв аймгийн Баяндэлгэр сумын трахибазальтын илрэлд эрэл, хайгуулын ажил хийж, нөөцийг тогтоон, эрдсийн хөвөнгийн түүхий эд болгон ашиглах зорилгоор Улаанбаатар хотын СБД-т бүртгэлтэй “Монгол базальт” ХК нь ашиглалт явуулах 17426А тоот тусгай зөвшөөрлийг 2013 оны 11-р сарын 29-нд авсан юм. Талбай нь L-49-13 хавтгайд дараах солбицолуудаар хязгаарлагдах 32.39 гектар хэмжээтэй.

Тусгай зөвшөөрөлтэй талбайн өнцгүүдийн солбицол:

MV-017426

1.  $108^{\circ} 09' 50''$   $47^{\circ} 30' 12''$
2.  $108^{\circ} 10' 15''$   $47^{\circ} 30' 12''$
3.  $108^{\circ} 10' 15''$   $47^{\circ} 29' 52''$
4.  $108^{\circ} 09' 50''$   $47^{\circ} 29' 52''$

Талбайн байршлын зураг



Зураг 1. “Ногоон уул” базальтын ордын байршил

Хайгуулын энэ талбай нь Төв аймгийн Баяндэлгэр сумын нутагт Хар толгойн орчим, Улаанбаатараас 158 км, Архуст сумаас 40 км, Баяндэлгэрийн 3-р бригадаас 16 км, Багануурын нүүрсний уурхайгаас 35 км зайтай оршино.

## 1.2. Орчны төлөв байдал

*Газрын гадарга:* Физик газарзүйн мужлалаар хээр талын мужид багтдаг намхан бэсрэг уулархаг бүсэд багтдаг, Бөөрөлжүүтийн нуур, Цагаан нуур зэрэг давст нуур, хужир марз бүхий Галуутын хөндий зэрэг томоохон хоолойтой. Энэ орчиндоо Улаан уул 1499.0 м, Шивээ ухаа овоо 1439.8 м өндөртэй /далайн түвшинээс дээш/ хамгийн нам цэг нь Галуутын голд 1309 м.

*Усан сүлжээ:* Дунд зэрэг хөгжсөн. Хэрлэн голд цутгах Галуутын гол, Дэлбэрэхийн гол, Тал булаг, Бор булаг зэрэг булаг, жижиг давстай нууруудтай, ихэнх булаг ширгэсэн. Тухайн жилийн хур тунадасны хэмжээнээс хамаарч, усны горим хувирамтгай зарим үед хатаж ширгэдэг хүн малын хэрэгцээнд голлон гол, булаг, худгийн ус хэрэглэгддэг, өвлийн улиралд цасны ус хэрэглэдэг байна.

*Уур амьсгал:* Судалгааны талбай нь эх газрын эрс тэс уур амьсгалтай. Жилд унах хур тунадасны хэмжээ 235.0 мм орчим бөгөөд хур тунадас ихэвчлэн уулархаг нутгаар унадаг. Жилийн дундаж температур  $-3^{\circ}\text{C}$ , хамгийн дулаан нь 7-р сард  $+35^{\circ}$  хамгийн хүйтэн үе нь 1-сард  $-30^{\circ}\text{C}$  байдаг.

*Ургамал зүй:* Өвс, таана, хөмүүл зэрэг амтлаг ургамал, харгана дэрс зэрэг мод, бутлаг ургамал ургана.

*Ан амьтад:* Тарвага, үнэг, хярс, туулай, зараа, могой байдаг. Жигүүртнээс хахилаг, хуланжороо, болжмор, тагтаа, ногтруу, бүргэд, тас бий.

*Дэд бүтэц:* Сонгосон талбай нь дулаалгын чулуун хөвөнгийн гол түүхий эд болох базальтлаг чулуулаг өргөн тархсан, дэд бүтэц маш сайн хөгжсөн буюу Улаанбаатар-Бага нуурыг холбосон төмөр болон хатуу хучилттай замын ойролцоо, өндөр хүчдэлт цахилгаан шугамтай. Улаанбаатар хотод ойрхон оршдог онцлогтой. Энэ нутагт Баяндэлгэр сумын малчид мал аж ахуй эрхлэн амьдарна. Сумын төвд сумын захиргаа, хүн эмнэлэг, холбоо, дунд сургууль, шатахуун түгээх газар, дэлгүүр зэрэг соёл үйлчилгээний байгууллага, Мобиком, Скайтелийн харилцаа холбоотой. Хээрийн үйлдвэрлэлийн ажил явуулахад 4-р сарын 15-наас 10-р сарын 15-ны хооронд тохиромжтой. Талбайгаас Мобиком, Юнитель сүлжээнд холбогдоно.

## 3. Ил уурхайн 2022 оны үйл ажиллагаа

Уурхай нь 2022 онд Экскаватор-1, Утгуурт ачигч-1, Автосамосвал-1 ажиллаж нийт 2,2 мян.тн базальт чулуулаг олборлон 1,38 мян.тн үйлдвэрийн стандарт хангасан базальт ангилж ялгаж үйлдвэрлүү ачууллаа.

“Ногоон уул” базальтын ил уурхайг ашиглах үйл явц нь дараах технологийн бүдүүвчийн дагуу явагдсан. Үүнд:

өрөмдлөг тэсэлгээ ► хөрс хуулалт ► олборлолт ► тээвэрлэлт ► шигших ► түр овоолго үүсгэх ► бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрийн талбай рүү хүргэх гэсэн технологийн үндсэн горимын дагуу ажилласан.

**Нөөцийн нэгдсэн хүснэгт**

Д/д	Нөөцийн зэрэглэл Бодит (В) Боломжтой (С)	Блокын дугаар	Блокийн талбай (S), кв.м	Зузаан (m), м		Эзэлхүүн (V), м <sup>3</sup>		Эзэлхүүн (d) жин г/см <sup>3</sup>	Ашигт малтмалын нөөц, тонн	Хөрс хуулалтын коэффициент
				Хучаас хурдас	Ашигт малтмал	Хучаас хурдас	Ашигт малтмал			
1	Бодит нөөц (В)	Блок В-I	25314	0.37	17.43	9366.2	441223.02	2.35	1036874.1	1:47
		Блок В-II	23301.8	0.39	18.16	9087.7	423160.69	2.35	994427.6	1:46
		В-I+ В-II				18453.9	864384.7		2031301.7	
2	Боломжтой нөөц (С)	Блок С-III	7340	0.57	14.6	4183.8	107164	2.35	251835.4	1:25
		Блок С-IV	8913.4	0.6	16.23	5348.0	144664.48	2.35	339961.5	1:27
		С-III+ С-IV				9531.8	251828.5		591797	

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ**

- Уурхайн эдэлбэр газрын агаарын бохирдолтыг аль болох бага байлгах үүднээс уурхайн авто замуудыг дулааны улиралд тогтмол услах болон тэсэлгээний үед тоосжилт бага байлгах тал дээр анхаарч цэнэгийн түгжээсэнд бутлаж бэлтгэсэн дайрга ашиглах, тэсэлгээний мөргөцгийг тэсэлгээний өмнө усалгаа хийж чийгшүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр шинэчлэн гаргаж батлуулан төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж явах бөгөөд түүнд гарах зардлыг нөхөн сэргээлт байгаль хамгаалах зардлын тооцоо хэсэгт тодорхой тусгасан болно.
- Уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөг хийхдээ гадаад овоолгод дарагдах талбайг боломжит хамгийн бага байлгах зорилтод тулгуурласан байгаа.
- Ашиглалтын явцад зөвхөн технологийн процессуудад зайлшгүй шаардлагатай замуудыг байгуулан, маршрутыг тогтоож, тоног төхөөрөмжүүдийг парклах талбайнуудыг тусгайлан байгуулах замаар онц шаардлагагүй олон салаа зам гарч газрын гадарга эвдэгдэхээс сэргийлнэ гэж үзэж байна. Зам, талбайд ашиглагдах нийт талбайг уурхайн ашиглалт дууссаны дараагаар нөхөн сэргээнэ.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
 ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ**

**3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу  
 хийгдсэн ажил**

*Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал*

№	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хариуцах эзэн
<b>1. Агаарын чанар</b>			
1.1	Агаарын чанар хэмжүүлнэ./ 1 удаа/	ОХШХ-ийн зардлаас	Төсөл гүйцэтгэгч, БО-ны улсын байцаагч
1.2	Ажилчдын эрүүл мэндийг үзүүлж мэргэжлээс шалтгаалах өвчний байдлыг тодорхойлох (ажилд авахдаа)	Удирдлага зохион байгуулалтын зардлаас	
	Нийт зардал /мян.төг/	-	
<b>2. Газрын гадарга, газар доорх усан орчин</b>			
2.1	Уурхайн дотор болон уурхайн ойр орчимд хатуу ба шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүн хаяхгүй байх (урьдчилан сэргийлэх арга хэмжээнд)	Дотоод зардлаар	Төсөл гүйцэтгэгч, БО-ны улсын байцаагч, хяналтын инженер
2.2	Усны шинжилгээ хийлгэнэ. /1 удаа /	ОХШХ-ийн зардлаас	
	Нийт зардал /мян.төг/	-	
<b>3. Хөрсөн орчин</b>			
3.1	Хатуу хог хаягдал ахуйн химийн бодисыг эмх цэгцтэй хадгалах	Хог хаягдлын менежментийн зардлаас	Төсөл гүйцэтгэгч, БО-ны улсын байцаагч, хяналтын инженер
3.2	Техникийн засвар үйлчилгээг тусгай талбайд явуулах	Дотоод зардлаар	
3.3	Хөрсний шинжилгээг ОХШ хөтөлбөрт заасан хугацаанд хийлгэх /1 удаа /	ОХШХ-ийн зардлаас	
3.4	Тээвэрлэлтийн зам болон уурхайн тоосжилтыг шавхалтын ус ашиглан чийгшүүлнэ.	Дотоод зардлаар	
	Нийт зардал /мян.төг/	-	
<b>4. Ургамлан нөмрөг</b>			
4.1	Уурхайн олборлолтын талбай ургамал талхлагдсан газруудад хамгаалалт хийж, байгаль өөрөө сэргэх боломжийг бүрдүүлэх	Дотоод зардлаар	Төсөл гүйцэтгэгч, БО-ны улсын байцаагч, хяналтын инженер
	Нийт зардал /мян.төг/	-	
<b>5. Байгаль орчны менежментийн асуудал</b>			
5.1	Болзошгүй аюулын үед орон нутгийн онцгой байдлын газартай хамтран ажиллах	200	Төсөл гүйцэтгэгч,

5.2	Ослын үед ажиллах ИТА, ажилчдын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж сургалт явуулах	200	БО-ны улсын байцаагч, хяналтын инженер
	Нийт зардал /мян.төг/	400	
	<b>Бүгд зардал /мян.төг/</b>	<b>400</b>	

### 3.2. Уурхайн нөхөн сэргээлт

Ордод урьд өмнө хайгуул явуулсан ил малталтуудын гарш хэсгийн ухаш, уулын ажлын улмаас бий болсон цөмрөлт, хотойлт үүссэн талбайнуудад техникийн нөхөн сэргээлтийг хийсэн.



Зураг 2. Техникийн нөхөн сэргээлт хийгдэж буй явцын байдал





*Зураг 3. Техникийн нөхөн сэргээлт хийгдэж буй явцын байдал*



*Зураг 4. Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай*



### **3.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ**

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд бөгөөд тухайн онд ямар нэг ажлыг төлөвлөөгүй болно.

### **3.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ**

Уурхайн лицензийн талбайтай давхцалтай айлын өвөлжөөний газар байхгүй тул айл нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй болно.

### **3.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ**

Тусгай зөвшөөрлийн талбайд палеонтологийн олдворын ул мөр ажиглагдаагүй байна. Түүнчлэн археологийн дурсгал илрээгүй байна.

Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

### **3.6 Химийн бодисын эрсдлийн менежмент**

Уурхайн үйл ажиллагаанд түлш болон тэсэлгээнд хэрэглэх эмульсээс өөр химийн бодис урвалж хэргэлдэггүй тул химийн хорт бодис урвалжаас үүсэх эрсдлийн менежментийн төлөвлөгөө гаргаагүй болно.

### **3.7 Хог, хаягдлын менежмент**

Уурхайн үйл ажиллагаа нь улирлын чанартай явагддаг бөгөөд жилд 10-15 хоногт ажилладаг. Үйл ажиллагааны явцад үүсэх ахуйн болон техникийн хог хаягдлыг тусгайлан хаягдлын цэг байгуулахгүйгээр чулуу Багануурлуу ачихдаа тусгай уут саванд хийж Багануурын хаягдлын цэгт хаядаг. Мөн Баганууртай хог хаягдлын гэрээ хийн төлбөр төлдөг.

### **3.8 Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежмент**

#### **Хүснэгт 2. Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал**

<b>Нөлөөллийг бууруулах арга хэмжээ</b>	<b>Зардал, мян.төг</b>
Энэхүү тайлангийн сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлж ажиллаа.	--*--
Ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулж, хамруулах	500.0
Ажиллагсдыг улиралд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах.	-
<b>Нийт зардал</b>	<b>500.0</b>

### 3.9 Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу агаар, ус, хөрсний шинжилгээнүүдийг өгсөн болно.

#### Хүснэгт 3. Орчны хяналт шинжилгээний ажлын зардал

Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал
<b>Агаарын чанар</b>				
SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , CO, Тоос	Уурхайн гол замын орчим, 0, 1, 2 км-ын зайн алслалтаар салхин доод талд,	Жилд 1 удаа, хавар, намар	<b>200.0</b>	MNS4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
<b>Газар доорх ус</b>				
Усны чанарын стандартад заасан үзүүлэлтүүд	Ашиглаж буй уст цэгүүдэд	Жилд 1 удаа	<b>100.0</b>	MNS 4586-98 Усан орчны чанарын үзүүлэлт MNS 9000:2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
<b>Хөрсөн бүрхэвч</b>				
Хөрсний нефть бүтээгдэхүүний бохирдол	Уурхайн орчим	Жилд 1 удаа	<b>100.0</b>	
<b>Төслийг хэрэгжүүлэх эхний жилийн зардлын урьдчилсан дүн</b>			<b>400.0</b>	

### 3.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

#### Хүснэгт 4. Төслийн төлөвлөлт, биелэлтийг тайлагнах хуваарь

№	Ажлын нэр	Хэнд	Хариуцах эзэн	Хугацаа
1	2022 оны үйл ажиллагаа эхлэхээс өмнө төсөл хэрэгжих талбайн өнөөгийн байдлыг танилцуулах	Төсөл хэрэгжих талбай орчмын нутгийн иргэд, холбогдох хүмүүс	Уурхайн дарга, Байгаль орчны мэргэжилтэн	V сард
2	Нийт хийгдсэн ажлын хэмжээ, хийгдсэн ажлуудын тайлагнал	Төсөл хэрэгжих талбай орчмын нутгийн иргэд, сумын байгаль орчны байцаагч, холбогдох хүмүүс	Уурхайн дарга, Байгаль орчны мэргэжилтэн	X сард



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: [bohzt@gmail.com](mailto:bohzt@gmail.com)



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/ № : 2022/ 673-674  
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : " Монгол базальт "ХК  
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : Б.Батхишиг, агаарын хэсгийн техникч  
Дээжийн тоо, төрөл : 2, хөрсний сорьц  
Хүлээн авсан огноо : 2022.10.18  
Дээжийн тодорхойлолт : Төв аймаг, Баяндэлгэр сум, 3-р баг,  
Ногоон уул уурхай  
Шинжилгээний аргын стандарт : САЗ Х:2016  
Шинжилсэн огноо : 2022.10.20  
Хуудасны тоо : 1/1  
Үр дүн:

№	Сорьц авсан цэгийн нэр	Кадьми (Cd)	Хар тугалга (Pb)	Мөнгөн ус (Hg)	Хром (Cr)	Цайр (Zn)	Зэс (Cu)	Кобальт (Co)	Стронци (Sr)
1	Уурхайн салхин дээр	илр	9.5	илр	илр	168.8	28.6	61.8	791.5
2	Уурхайн ам салхин доор	илр	12.2	илр	илр	131.5	28.8	66.1	897.4
<b>MNS 5850:2019 / ЗДХ/</b>		<b>3</b>	<b>100</b>	<b>2</b>	<b>150</b>	<b>300</b>	<b>100</b>	<b>50</b>	<b>800</b>

Тайлбар: илр-илрээгүй

Шинжилгээ гүйцэтгэсэн  
Хөрсний хэсгийн инженер

Хянаж баталгаажуулсан  
Хөрсний хэсгийн инженер



Д.Баярхулан

Б.Даваасүрэн

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн дээжинд хүчинтэй



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: [bohzt@gmail.com](mailto:bohzt@gmail.com)



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№	: 2022/ 206
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Монгол Базальт” ХК
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал	: Б.Батхишиг, БОХЗТЛ
Сорьцын тоо, төрөл	: 1, ус
Сорьцыг авсан огноо	: 2022.10.18
Сорьцын тодорхойлолт	: Усны сорьц
Шинжилгээний аргын стандарт	<b>MNS ISO 10523:2001, MNS ISO 7888:1999, MNS 6271:2011, MNS 4424:2005, MNS 1097:1970</b>
Шинжилсэн огноо	: 2022.10.18-10.26
Хуудасны тоо	: 2 /2
Үр дүн	:1

Сорьцын нэр	pH	EC µS/cm	SO <sub>4</sub> мг/л	Cl мг/л	Ca мг/л	Mg мг/л	Na+K мг/л	HCO <sub>3</sub> мг/л	Эрд мг/л	Хат мг-экв/л
Төв аймаг Баяндэлгэр сум Худгийн ус	7.47	846	97.3	56.0	126	26.4	8.8	317	631	8.46
<b>MNS 0900:2018</b>	<b>6.5-8.5</b>	<b>1000</b>	<b>100</b>	<b>30</b>	<b>-</b>	<b>500</b>	<b>350</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>7.0</b>

Тайлбар: EC - цахилгаан дамжуулах чанар, Хат-Хатуулаг, Эрд-Эрдэсжилт

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер:  Б.Жавзандулам

Хянаж баталгаажуулсан инженер:  Ц.Мийдүв

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.





ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: [bohzt@gmail.com](mailto:bohzt@gmail.com)



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2022/394  
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Монгол Базальт" ХК  
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : Б.Батхишиг агаарын хэсэг  
Дээжийн тоо, төрөл : 2 агаар ,2 дуу чимээ  
Сорьц авсан огноо : 2022.10.17  
Дээжийн тодорхойлолт : Төв аймаг,Баяндэлгэр сум,3-р баг  
Ногоон уул базальтын уурхай  
Шинжилгээний аргын стандарт : MNS 17.2.5.12:88, MNS 17.2.5.11:88,DUSTRAK8530  
Шинжилсэн огноо : 2022.10.20  
Хуудасны тоо : 1/1

Үр дүн :

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м <sup>3</sup>	Азотын давхар исэл мг/м <sup>3</sup>	Нийт Тоос /TSP/ мг/м <sup>3</sup>	Дуу чимээ /ДБА/
1	Уурхайн салхин дээр карьер орчим N 47°30'05.18", E 108°01'0.8"	X/6	12:30	0.012	0.030	0.096	42
2	Уурхайн ам орчим N 47°30'00.5", E 108°01'0.9"	X/6	12:50	0.014	0.027	0.115	38
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн:  
Агаарын хэсгийн техникч

Хянаж баталгаажуулсан:  
Агаарын хэсгийн инженер



Д.Сувд

Д.Түмэндэлгэр

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй